

## Журам шинэчлэн батлах тухай

“Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-ын 5.5, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бүртгэх, дугаар олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс /Ц.Оюунбат/-т даалгасугай.
3. Энэ журам батлагдсантай холбогдуулан “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/14 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ХЯНАСАН:

ХЗХБХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

ЗСХ-ИЙН ДҮТӨГ

Э.ОСОРЖАМАА

ЗСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

О.АНУЖИН

БОЛОВСРУУЛСАН:

ХЗХБХ-ИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Г.БАЯРСАЙХАН

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”  
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 201 ... оны  
... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалын  
хавсралт

## ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН, ЧИНГЭЛЭГ БҮРТГЭХ, ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд Монгол Улсын хилээр шинээр нэвтрүүлж байгаа болон одоо ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн улсын бүртгэл хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бүртгэх, дугаар олгох үйл ажиллагааг улсын хэмжээнд “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид “Төв” гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

1.3. Төмөр замын тээвэрт ашиглахаар Монгол Улсын хилээр шинээр нэвтрүүлж байгаа болон тээвэрлэлтэд ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын бүртгэлд бүртгүүлж дугаар аваагүй тохиолдолд төмөр замын тээврийн хөдөлгөөнд оролцуулахгүй.

### Хоёр. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бүртгэх, дугаар олгох

2.1. Хөдлөх бүрэлдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэж, дугаар олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шуурхай, хууль тогтоомжийн дагуу байх зарчим баримтална.

2.2. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг энэхүү журам, Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 2, 3-р хэсэг. “Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага”, “Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага” MNS 6630-2, 3:2016” стандартыг мөрдөн дугаар олгож, мэдээлийн сангийн батлагдсан загварын дагуу хөдлөн бүртгэнэ.

2.3. Улсын бүртгэлд дараах хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэж дугаар олгоно:

- 2.3.1. зүтгүүр;
- 2.3.2. бүх төрлийн ачааны вагон;
- 2.3.3. чингэлэг;
- 2.3.4. гал унтраах галт тэрэг;
- 2.3.5. төмөр замаар явдаг бусад техник /нэгж бүрээр/ өөрөө явагч;
- 2.3.6. сэргээн босгох галт тэрэг.

2.4. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бүртгэх, дугаар олгох хүсэлтийг дараах журмаар хянан шийдвэрлэнэ:

2.4.1. Хүсэлт гаргагчийн баримт бичгийн иж бүрдэл, гэрчилгээний нөхцөл шаардлага хангасан байдлыг нягтлан шалгасан дүгнэлтийг үндэслэн улсын бүртгэл хийж дугаар олгох болон олгохоос татгалзахыг шийдвэрлэх;

2.4.2. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг ашиглалтын хугацаа дууссан тохиолдолд эрх бүхий мэргэжлийн байгууллагын техникийн оношилгооны дүгнэлтийг үндэслэн их засвар болон урсгал засварт оруулж, ашиглалтын хугацааг сунгахыг төрийн захиргааны төв байгууллагаас томилсон мэргэжлийн хяналтын ажлын хэсгийн дүгнэлтээр шийдвэрлэнэ.

2.5.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бүртгэх, дугаар олгоход дараах баримт бичгийг үндэслэнэ:

2.5.1.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгт дугаар олгохыг хүссэн албан бичиг;

2.5.2.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг эзэмшигч хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар (нотариатаар баталгаажуулсан байна.);

2.5.3.Импортоор шинээр оруулж ирсэн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бол техникийн паспорт болон үйлдвэрлэгчийн дагалдах бичиг;

2.5.4.Ашиглагдаж байгаад импортоор оруулж ирсэн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн гэрчилгээ, тухайн улсын эрх бүхий байгууллагаас техникийн шаардлага хангаж байгааг тодорхойлсон дүгнэлт, тухайн улсын бүртгэлээс хассан тухай тодорхойлолт, тэмдэглэл;

2.5.5.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг нь төмөр замын тээврийн хөдөлгөөнд тэнцэх эсэх тухай төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсгийн дүгнэлт, эрх бүхий байгууллагын баталгаа;

2.5.6.Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг үйлдвэрлэх, угсрах, засварлах, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын баталгаажуулсан баримт бичиг;

2.5.7. Импортоор шинээр оруулж ирсэн тохиолдолд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн гаалийн бүрдүүлэлт хийснийг нотлох мэдүүлэг, баримт.

2.6.Энэхүү журмын 2.5-д заасан баримт бичгийг бүрдүүлсэн бол зохих журмын дагуу хянан ажлын 14 хоногт, нэмэлт судалгаа, тодруулга шаардлагатай бол уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгана.

2.7.Энэ журмын 2.5-д заасан баримт бичиг бүрдүүлэлт дутуу бол бүртгэл хийгдэхгүй.

2.8.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн төрөл, зориулалт, загвар, марк, сери дугаараас үл хамааран дугаар давхардуулж олгохыг хориглоно.

2.9.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг үйлдвэрлэгч байгууллагын нэр, үйлдвэрлэсэн огноо, оноосон нэр ба сери дугаар, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн дугаар зэрэг нь ашиглалтын хугацааны туршид өөрчлөгдөхгүй.

### **Гурав. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг шилжилт хөдөлгөөн, өөрчлөлт бүртгэх**

3.1.Хөдлөх бүрэлдэхүүн, шилжилт хөдөлгөөн дараах тохиолдолд бүртгэгдэнэ. Үүнд:

3.1.1.Өмчлөгч иргэн, хуулийн этгээд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг худалдах, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлсэн;

3.1.2.Хөдлөх бүрэлдэхүүний төрөл, хийц, хөдөлгүүр, арал чингэлгийн зориулалт өөрчлөгдсөн;

3.1.3.Хуулийн этгээд улсын бүртгэлээс хасагдсан болон өмчлөгч иргэн нас барсан.

3.2.Өмчлөгч нь энэ журмын 3.1.-д заасан шилжилтийг 14 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй.

3.3 Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн шилжилт хөдөлгөөнийг дор дурдсан баримт бичигт үндэслэн бүртгэнэ. Үүнд:

3.3.1. Иргэн болон хуулийн этгээдэд шилжүүлсэн болон шилжүүлж авсан иргэн, хуулийн этгээдийн шийдвэр, албан бичиг, бүртгэлийн маягт, шилжүүлснийг нотлох бусад баримт бичиг.

3.3.2. Шилжүүлэн авч байгаа өмчлөгч иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.3.3. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн гэрчилгээ;

3.4. Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч иргэн нас барсан тохиолдолд өв залгамжлалын гэрчилгээ үндэслэн бүртгэнэ.

3.5. Өмчлөгч аж ахуйн нэгж татан буугдсан тохиолдолд хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчдын хүсэлт, улсын бүртгэлийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шилжилт хийж болно.

3.6. Хөдлөх бүрэлдэхүүний төрөл, хийц хөдөлгүүр, арал өөрчилсөн тохиолдолд тухайн өөрчлөлт техникийн шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, өмчлөгчийн хүсэлтээр өөрчлөлт хийнэ.

3.7. Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч нь түүнд оруулсан өөрчлөлтийн талаарх мэдээллээ 14 хоногийн дотор төвд мэдэгдсэн байна.

### **Дөрөв . Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг худалдах болон худалдан авагч талуудын өмчлөл шилжүүлэх**

4.1. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг худалдах болон худалдан авагч иргэн, аж ахуй нэгж байгууллага нь дараах баримт бичгийн бүрдлийг төвд ирүүлнэ:

4.1.1. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн өмчлөл шилжүүлэхийг хүссэн худалдаж байгаа болон худалдан авагч талуудын албан бичиг;

4.1.2. Өмчлөгч иргэн бусдад шилжүүлсэнийг нотолж гарын үсгээ зурж баталгаажуулах, худалдах, худалдан авах, бэлэглэх, арилжааны гэрээ, бусдад шилжүүлэхийг зөвшөөрсөн итгэмжлэлийг тус тус нотариатаар батлуулсан байх;

өмчийн болон төрийн өмчийн бус оролцоотой хуулийн этгээд бол Төрийн өмчийн хороо /аймаг, нийслэлийн өмчийн газар/-ны шийдвэр;

4.1.3. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжилт хөдөлгөөн хийхийг хязгаарласан бол түүнийг дуусгавар болгосон тухай шийдвэр;

4.1.4. Өмчлөх эрх шилжүүлсэн, баталгаажуулсан тухай шүүхийн шийдвэр;

4.1.5. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг эзэмшигч, өмчлөгч хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар;

4.1.6. Импортоор оруулж ирсэн шинэ бол хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн техникийн паспорт, үйлдвэрлэгчийн дагалдах бичиг;

4.1.7.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсгийн дүгнэлт;

4.1.8.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгт засвар үйлчилгээ хийсэн эрх бүхий газрын баримт;

4.1.9.Хөдлөх бүрэлдэхүүн нь тусгай тоноглол суурилагдсан тээврийн хэрэгслийн хувьд нэмэлт төхөөрөмжийн техникийн байдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан дүгнэлт.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан баримт бичгийн бүрдэлийг зохих журмын дагуу хянан судлаад ажлын 14 хоногт, нэмэлт судалгаа, тодруулга шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоногоор сунган судлаж хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл шилжүүлсэн бүртгэл хийгдэнэ.

4.3. Иргэний хуулийн 244 дүгээр зүйлийн 244.1-д заасныг үндэслэн өмчлөлийн шилжилт хөдөлгөөнийг хийж бүртгэлд оруулна.

4.4. Өмчлөл шилжүүлэгдсэн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн биет байдал болон чанартай холбоотой асуудалд төв хариуцлага хүлээхгүй болно.

#### **Тав . Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бүртгэлээс хасах**

5.1.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг Монгол Улсаас экспортлох тохиолдолд өмчлөгч нь бүртгэлээс хасуулна.

5.2.Хөдлөх бүрэлдэхүүн осол аваарын улмаас ашиглалтаас хасах хэмжээнд хүрсэн /комиссын шийдвэрээр/

5.3.Хөдлөх бүрэлдэхүүн, бүртгэлээс хасах тохиолдолд дараах баримт бичигт үндэслэнэ. Үүнд:

5.3.1.бүрэлдэхүүнийг бүртгэлээс хасуулах өмчлөгчийн хүсэлт;

5.3.2.хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн гэрчилгээ.

5.4. Төв нь хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгчийн 4.3-т заасан баримт бичгийг үндэслэн бүртгэлээс хассан тэмдэглэл хийнэ.

5.5. Бүртгэлээс хассан хөдлөх бүрэлдэхүүний баримт бичиг нь зохих журмын дагуу архивт хадгалагдана.

#### **Зургаа . Бусад зүйл**

6.1. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн бүртгэл, дугаар олголт, шилжилт хөдөлгөөн хийх, бүртгэлээс хасах үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг төвд гаргах ба уг гомдолд хуульд заасан хугацааны дотор хариу өгнө.

6.2. Иргэн, хуулийн этгээд энэхүү журмын 6.1.-д заасан санал, гомдлын талаар гаргасан төвийн шийдвэрийг эс зөвшөөрвөл төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад болон шүүхэд гомдол гаргах эрхтэй.

6.3. Энэхүү журам зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.